



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар A152

Бор-Өндөр сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.4, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Аравдугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Э.Отгонтунгалаг                      Байгаль орчны Хяналтын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

Б.Цогзолмаа                          2 дугаар багийн зохион байгуулагч

Гишүүд:

Б.Баярбаясгалан                      Байгаль хамгаалагч

Э.Эрдэнэбат                          “Бор-Өндөр Хот тохижилт” ТБАУГТҮГазрын дарга

И.Энхтуяа                                1 дүгээр багийн Засаг дарга

У.Пүрэвсүрэн                         2 дугаар багийн Засаг дарга

Д.Мөнгөнтуяа                         3 дугаар багийн Засаг дарга

Ч.Саруулмөнх                         4 дүгээр багийн Засаг дарга


Б.Мөнх-Оргил                         5 дугаар багийн Засаг дарга

Н.Отгонбилэг	6 дугаар багийн Засаг дарга
Х.Балгансүрэн	"Ногоон дэлхийн дуудлага" ТББ-ын тэргүүн
Ө.Нямжав	Олон нийтийн байцаагч
Г.Жадамба	Аравтын ахлагч
С.Батсайхан	Аравтын ахлагч
Д.Наранцэцэг	Аравтын ахлагч
Ч.Энхжаргал	Аравтын ахлагч
М.Цэцэгмаа	Аравтын ахлагч

2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох эрхзүйн баримт бичгийг үндэслэн боловсруулж 2026 оны 04 дүгээр сард багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Отгонтунгалаг/-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Х.Галбадрах/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ